ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2026 оны 07 сарын 29 өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, "Худалдаа, хөгжлийн банк" ХК (цаашид "Банк" гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны холбогдох этгээд болох "Аурум Металс" ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй "Зээлийн нэмэлт гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
TRADE AND DEVELOPMENT BANK JSC

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **РАНДОЛФ КОППА**